

**Аудитын код: САГ-2018/72/СТА-ТӨҮГ**

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)

Аудитын менежер С.Оюунгэрэл  
Утас: 261885 Цахим хаяг: [oyungerels@audit.gov.mn](mailto:oyungerels@audit.gov.mn)

Аудитор О.Баярмаа  
Утас: 261740 Цахим хаяг: [bayarmaao@audit.gov.mn](mailto:bayarmaao@audit.gov.mn)

## НЭГ. АГУУЛГА

1. Оршил
2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, эрх зүйн орчин
4. Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар
9. Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдлүүд
10. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
11. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
12. Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
14. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар
15. Зөрчилгүй санал, дүгнэлт





**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

РАДИО ТЕЛЕВИЗИЙН ҮНДЭСНИЙ  
СҮЛЖЭЭ УТҮГ-ЫН ЗАХИРАЛ  
С.ЦАГААНХҮҮ ТАНАА

2018.03.15 № 06/706  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Радио телевизийн үндэсний сүлжээ УТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Радио телевизийн үндэсний сүлжээ УТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Радио телевизийн үндэсний сүлжээ УТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10.20\Bichig\_Khereg\Yawsan\_Bichig\2018\0315SAG38.Docx




### Үүрэг, хариуцлага

Радио телевизийн үндэсний сүлжээ УТҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ  
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ



\\10.10.10.20\Bichig\_Khereg\Yawsan\_Bichig\2018\0315SAG38.Docx



## Аудитын тайлан

### 1. Оршил

“Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ-ын 2017 оны санхүүгийн жилийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

### 2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.


Аудитыг Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

“Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/ түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн үйлдвэрийн газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Байгууллагын удирдлага санхүүгийн тайлангаа Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/ түүнд нийцүүлсэн Сангийн сайдын баталсан холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС болон УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

“Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 01 дүгээр сарын 24-ний өдрөөс 2018 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн хооронд хийхээр төлөвлөн “Өлзийт экаунт хэрэгжүүлэв.”



“Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайланг 2018 оны 2 дугаар сарын 23-ны өдрийн 01/63 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

Аудитыг 2018 оны 1 дүгээр сарын 24-ний өдрөөс 2017 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг хуулийн хугацаанд “Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ-ын удирдлагад гардуулна.

### **3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, эрх зүйн орчин:**

“Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ-ын гол зорилго нь “Харилцаа холбоо, мэдээлэл технологийн шинэ дэвшилтэт технологийг ашиглан хэрэглэгчдийн өнөөгийн болон ирээдүйн хэрэгцээг хангасан нийлмэл, орон зайнаас үл хамаарсан радио, телевизийн өргөн нэвтрүүлгийн үндэсний тоон технологийн сүлжээг өргөжүүлэн хөгжүүлэх”-д оршино.

Тус байгууллага нь үйл ажиллагааны зорилтоо биелүүлэхэд дараах хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

1. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3-т “Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр төсвийн хөрөнгөөр санхүүждэг, зөвхөн төрийн хэрэгцээнд зориулсан үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ эрхэлдэг хуулийн этгээдийг улсын төсөвт үйлдвэрийн газар гэнэ”,

2. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т “Улсын төсөвт байгууллага нь өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмших, ашиглах; улсын төсвөөс олгосон хөрөнгийг Төсвийн тухай хуульд заасны дагуу зарцуулж, тайлагнах” гэж заасантай нийцүүлэн үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

“Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ-ын удирдлага нь Төсвийн тухай хууль, болон Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Харилцаа холбооны тухай, Радио долгионы тухай, Зөрчлийн тухай хууль, Шилэн дансны тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

“Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ-ын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

### **4. Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим, түүний үр дүн**

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар “Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс байгууллагын удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан 17 горим, 34 сорилыг гүйцэтгэв.





“Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн найруулж өөрийн үйл ажиллагаанд мөрдөн ажиллаж байна.

“Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг Санхүүгийн тооцоолох компанийн “Acolous” програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

## 6. Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг төлөвлөсөн горимын дагуу сорьсон. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Төлөвлөлтийн шатанд дотоод хяналтын тогтолцооны мэдээллийг хангалтгүй бөглөж ирүүлсэн тул үр нөлөөтэй гэж тооцсон ба дахин хянахад бүртгэлээр тавих дотоод хяналтын үйл ажиллагаа дунд байна. Эдгээрийг асуудлын бүртгэлээр удирдлагад хүргүүлсэн болно.

## 6.Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

2017 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан байна.

“Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ-ын 2017 оны орлогын төлөвлөгөөний биелэлтийг дараах хүснэгтээр үзүүлэв.

/сая.төг/

Орлогын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт
Улсын төсвийн санхүүжилт	2,931.1	2,931.1	
Урьд оны санхүүжилт	3,143.1		-3,143.1
Үндсэн үйл ажиллагааны орлого	1,849.3	1,709.2	-140.0
Үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн орлого		10.2	10.2
Хүүгийн орлого		6.5	6.5
<b>НИЙТ</b>	<b>7,923.5</b>	<b>4,657.0</b>	<b>-3,266.5</b>

Улсын төсвийн санхүүжилт нь бүрэн орж ирсэн бөгөөд үндсэн үйл ажиллагааны орлого 140.0 сая төгрөгөөр тасарсан. Энэ нь эдийн засгийн хямралтай холбоотойгоор гэрээт телевизүүдийн санхүүгийн байдал хүндэрч гэрээний үүргээ биелүүлэх боломжгүй болж төлбөрөө төлж чадахгүй, мөн техник технологийн дэвшилттэй холбоотой байна.

Одоогийн байдлаар хот орчмын 16 гэрээт телевизийн 2 телевиз төлбөрөө төлж, бусад телевизүүд гэрээгээ цуцлах санал ирүүлсэн байгаа бөгөөд төлбөрөө барагдуулахгүй байна.



Төсвийн зарлагын гүйцэтгэлийг дараах хүснэгтээр үзүүлэв.

/сая.төг/

Зардлын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт
Цалин хөлс, нэмэгдэл, НДШ	2,683.0	2,521.7	161.3
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал	920.9	353,8	567.1
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,736.1	1,145.9	590.2
Хангамж, бараа материалын зардал	337.6	155.9	181.7
Эд хогшил худалдан авах	1,164.5	190.1	974.4
Томилолт, зочны зардал	274.1	106.5	167.6
Нормативт зардал	28.1	8.3	19.8
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	121.5	56.2	65.3
Бусад зардал	557.4	10.2	547.2
<b>НИЙТ</b>	<b>7,923.5</b>	<b>4,548.6</b>	<b>3,274.6</b>

“Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ-ын 2017 оны төсвийн гүйцэтгэлийн тайланг хавсралтаар үзүүлэв.

## 7. Шилэн дансны мэдээлэл

“Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ нь Шилэн дансны цахим хуудаст 1-9 дүгээр сар, 11-12 дугаар саруудын мэдээг хоцроосон, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээний мэдээг хугацаанд нь байршуулсан боловч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг байршуулаагүй байна.


Байгууллагын төсөв, хагас, бүтэн жилийн баталгаажсан санхүүгийн тайлан баланс, сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, өр авлагын мэдээ, төлбөрт үйлчилгээний үнэ тариф, журам зааврыг нээлттэй ил тодоор мэдээлж ирсэн байна.

## 8. Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 15 дансанд 28 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 34 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

## 9. Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдлүүд:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад горим сорил хэрэгжүүлсний үр дүнд Нягтлан бодох бүртгэлийн бодлогын болон бүртгэлийн шинж чанартай 4 алдааг олж тогтоосноос материаллаг бус 2 алдаа, материаллаг 2 алдаа зөрчил илрүүлснийг ач төрийн аудитын байгууллага





Эдгээр алдаанаас санхүүгийн тайлагналын батламж мэдэгдэл хангагдахгүй байх, өмч хөрөнгө шамшигдах, хариуцлагын тогтолцоо алдагдах, хууль тогтоомж дүрэм журам зөрчигдөх эрсдэл үүсч байна.

#### **Авлагын үлдэгдлийн талаар:**

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гаргахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг хэрэгжүүлээгүйгээс тайлант онд авлага 138.7 сая төгрөгөөр өссөн байна.

#### **Шийдвэрлэсэн нь:**

Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиудыг хэрэгжүүлж өр, авлага үүсгэхгүй, тухай бүр барагдуулж ажиллахыг менежментийн захидлаар зөвлөмж өгөх.

#### **Худалдан авах ажиллагааны зохион байгуулалтын талаар**

Богино долгионы станц худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа “Ньютелеком” ХХК нь гүйцэтгэх үнийн саналын маягтаар саналаа 14.1 сая төгрөгөөр ирүүлсэн байхад 1.4 сая төгрөгөөр илүү буюу 15.5 сая төгрөгөөр гэрээ байгуулсан байна. Тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны 6 дугаар зүйлийн 6.1-т “Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар хураамжийг оруулж, үнийн хуваарийн дагуу ирүүлнэ” гэж заасныг зөрчсөн байна.

Тайлант хугацааны туршид 4 удаагийн худалдан авах ажиллагааг зохион байгуулан үндсэн хөрөнгийг орлогод бүртгэсэн боловч байгуулсан гэрээний дүнгээс 10.5 сая төгрөгөөр илүү байна.

#### **Шийдвэрлэсэн нь:**

Тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны 6 дугаар зүйлийн 6.1-т “Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар хураамжийг оруулж, үнийн хуваарийн дагуу ирүүлнэ” гэж заасныг мөрдөн ажиллах.

Материаллаг бус дараах алдаанууд дотор техник технологийн хоцрогдолд орсон үндсэн хөрөнгийн талаар байгаа нь мөнгөн дүнгээр материаллаг хэмжээтэй боловч агуулга шинж чанарын хувьд материаллаг бус гэж үзэн дүгнэлтэд нөлөөлөхгүй.


#### **Үндсэн хөрөнгийн бүртгэлийн талаар**

Үндсэн хөрөнгийн шинж чанараар нь ангилж бүртгээгүй, элэгдэж хугацаа дууссан, үр ашиг буурсан, технологийн хоцрогдолд орсон хөрөнгийг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн дансны зааврын дагуу актлах санал бэлтгэж, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлж шийдвэрлүүлээгүй байна.

#### **Шийдвэрлэсэн нь:**

Үндсэн хөрөнгийн шинж чанарыг харгалзан үзэж эдийн засгийн ангиллын дагуу ангилж бүртгэлийг сайжруулах.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хөрөнгийг актлах санал бэлтгэж хүргүүлэн зөвшөөрөл авч шийдвэрлүүлж, хууль тогтоомжийг мөрдөн ажиллахыг менежментийн захидлаар зөвлөмж өгөх.



## **Бараа материалын зарцуулалтын талаар**

Тайлант хугацаанд 12.1 сая төгрөгийн бараа материалыг мөнгөн хөрөнгөөс шууд зардалд бүртгэж тайлагнасан байна.

### **Шийдвэрлэсэн нь:**

Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалыг хэрэгжүүлж бараа материалын дансанд орлого авч, анхан шатны санхүүгийн баримт бичгийг үндэслэн зарцуулалтыг тайлагнаж, хууль дүрэм журмыг мөрдөн ажиллахыг менежментийн захидлаар зөвлөмж өгөх.

### **10. Анхаарал татахуйц бусад чухал асуудал:**

“Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүний бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн дүнтэй дансанд гарсан ажил гүйлгээг, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа.

### **11. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:**

“Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар бидэнд мэдэгдэж байгаа баримтын хүрээнд гүйцээж мөшгөн шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

Харин үндсэн хөрөнгийн шинж чанар хангахгүй, үр өгөөж нь буурсан, техник технологийн хоцрогдолд орсон бараа материал, үндсэн хөрөнгө байгааг тоолж баталгаажуулаагүйг дараагийн аудитаар авч үзнэ үү.

### **12. Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:**

“Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 174.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба 11.7 сая төгрөгийн алдаа зөрчлийг залруулан, 162.8 сая төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж өгсөн.


### **13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:**

“Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар “Зөрчилгүй” санал дүгнэлт авсан бөгөөд аудитын байгууллагаас өгсөн 6 зөвлөмжийг 90 хувьтай биелүүлсэн байна.

Өмнөх аудитын тайлангаар дараагийн аудитаар авч үзвэл зохих асуудлыг тэмдэглэн үлдээснийг бид нягтлан үзсэн бөгөөд үндсэн үйл ажиллагааны орлогоо цуглуулан авахад хүндрэл гарч орлогыг балансаас гадуур бүртгэсэн байсан боловч тайлант оны үндсэн үйл ажиллагааны орлогод бүртгэн тайлагнасан байна.

### **14. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны нийт орлогын 1 хувийг 16.9 сая төгрөгөөр сонгов.



## 15. Зөрчилгүй санал дүгнэлт

“Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн шударга илэрхийлэгдсэн байна.

### “ӨЛЗИЙТ ЭКАУНТ АУДИТ” ХХК-ИЙН:

ХОЁР ДАХЬ ШАТНЫ ЧАНАРЫН ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛСЭН:

ЧАНАРЫН ХЯНАЛТЫН МЕНЕЖЕР

Э.ХҮРЭЛТОГОО

АНХАН ШАТНЫ ЧАНАРЫН ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛСЭН:

ЗАХИРАЛ

Ц.БЯМБАЖАВ

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Ч.ОЮУН

АУДИТОРЫН ТУСЛАХ

Г.ОЮУН-ЭРДЭНЭ



## **МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг “Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ-ын удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмж өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийгддэг Төрийн аудитын байгууллагын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан “Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ-ын удирдлага, санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.



<b>Асуудал 1: Авлагын үлдэгдлийн талаар:</b>	<b>Тэргүүлэх ач холбогдол №1</b>
----------------------------------------------	----------------------------------

**ҮАГ-ын ажиглалт**

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т зааснаар "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гаргахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг биелүүлж ажиллаагүйгээс тайлант онд 138.7 сая төгрөгөөр авлага өссөн байна.

**ҮАГ-ын зөвлөмж**

Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиудыг хэрэгжүүлж өр, авлага үүсгэхгүй, тухай бүр барагдуулж ажиллахыг менежментийн захидлаар зөвлөв.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 5 дугаар сарын 25 өдрийн дотор Үндэсний аудитын газарт албан бичгээр мэдэгдэх.

**Эрсдэлүүд**

Эрх ба үүрэг батламж мэдэгдэл хангагдахгүй байх, холбогдох хууль эрх зүйн актууд зөрчигдөх эрсдэл үүсч байна.

**Үйлчлүүлэгчийн хариу**

Аудитаар илэрсэн алдаа, зөрчил дутагдлыг асуудлын бүртгэлээр удирдлага хүлээн зөвшөөрсөн.



**Асуудал 2: Худалдан авах ажиллагааны зохион байгуулалтын талаар**

**Тэргүүлэх ач холбогдол №2**

**ҮАГ-ын ажиглалт**

Богино долгионы станц худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа “Ньютелеком” ХХК нь гүйцэтгэх үнийн саналын маягтаар саналаа 14.1 сая төгрөгөөр ирүүлсэн байхад 1.4 сая төгрөгөөр илүү буюу 15.5 сая төгрөгөөр гэрээ байгуулсан байна.

Тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны 6 дугаар зүйлийн 6.1-т “Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар хураамжийг оруулж, үнийн хуваарийн дагуу ирүүлнэ” гэснийг зөрчсөн байна.

Тайлант хугацааны туршид 8 удаа зохион байгуулснаас 3 удаагийн худалдан авах ажиллагаагаар үндсэн хөрөнгийг орлогод бүртгэсэн боловч байгуулсан гэрээний дүнгээс 10.5 сая төгрөгөөр илүү байна.

**Эрсдэлүүд**

Тохиолдсон байх батламж мэдэгдэл хангагдахгүй байх, хууль эрх зүйн актууд зөрчигдөх эрсдэл үүсч байна.

**ҮАГ-ын зөвлөмж**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлж, тендер зохион байгуулан сонгон шалгаруулалт хийж, гэрээ байгуулж ажиллах.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 5 дугаар сарын 25 өдрийн дотор Үндэсний аудитын газарт албан бичгээр мэдэгдэх.

**Үйлчлүүлэгчийн хариу**

Аудитаар илэрсэн алдаа, зөрчил дутагдлыг асуудлын бүртгэлээр удирдлага хүлээн зөвшөөрсөн.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**



**Асуудал 3: Үндсэн хөрөнгийн бүртгэлийн талаар**

**Тэргүүлэх ач холбогдол №3**

**ҮАГ-ын ажиглалт**

Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн дансны зааврын дагуу үндсэн хөрөнгийн шинж чанараар нь ангилж бүртгээгүй, элэгдэж хугацаа дууссан, үр ашиг буурсан, технологийн хоцрогдолд орсон хөрөнгийг актлах санал бэлтгэж, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлж шийдвэрлүүлээгүй байна.

**ҮАГ-ын зөвлөмж**

Үндсэн хөрөнгийн шинж чанарыг харгалзан үзэж эдийн засгийн ангилалын дагуу ангилж бүртгэлийг сайжруулах.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хөрөнгийг актлах санал бэлтгэж хүргүүлэн зөвшөөрөл авч шийдвэрлүүлж хууль тогтоомжийг мөрдөн ажиллахыг менежментийн захидлаар зөвлөмж өгөх.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 5 дугаар сарын 25 өдрийн дотор Үндэсний аудитын газарт албан бичгээр мэдэгдэх.

**Эрсдэлүүд**

Өмч хөрөнгө шамшигдах, хариуцлагын тогтолцоо алдагдах, нягтлан бодогчийн дадлага туршлага муугаас бодлогын шинжтэй бүртгэлийн алдаа гарах, эрсдэл үүсч байна.

**Үйлчлүүлэгчийн хариу**

Аудитаар илэрсэн алдаа, зөрчил дутагдлыг удирдлага асуудлын бүртгэлээр хүлээн зөвшөөрсөн.



<b>Асуудал 4: Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуулийн хэрэгжилтийн талаар</b>	<b>Тэргүүлэх ач холбогдол №4</b>
----------------------------------------------------------------------------------------	----------------------------------

**ҮАГ-ын ажиглалт**

Тайлант хугацаанд 12.1 сая төгрөгийн бараа материалыг мөнгөн хөрөнгөөс шууд зардалд бүртгэж тайлагнасан нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалыг зөрчсөн байна.

**ҮАГ-ын зөвлөмж**

Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалыг хэрэгжүүлж бараа материалын дансанд орлого авч, анхан шатны санхүүгийн баримт бичгийг үндэслэн зарцуулалтыг тайлагнаж хууль дүрэм журмыг мөрдөн ажиллахыг менежментийн захидлаар зөвлөмж өгөх.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 5 дугаар сарын 25 өдрийн дотор Үндэсний аудитын газарт албан бичгээр мэдэгдэх.

**Эрсдэлүүд**

Хэмжилт ба үнэн зөв байх батламж мэдэгдэл хангагдахгүй байх, хууль эрх зүйн актууд зөрчигдөх эрсдэл үүсч байна.

**Үйлчлүүлэгчийн хариу**

Аудитаар илэрсэн алдаа, зөрчил дутагдлыг асуудлын бүртгэлээр удирдлага хүлээн зөвшөөрсөн.




"Радио Телевизийн Үндэсний Сүлжээ" УТҮГ			
АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН			
2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар			
			(төгрөгөөр)
Дансны код	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
	<b>Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө</b>	<b>378,466,384.67</b>	<b>63,314,869.95</b>
	<b>Каасанд байгаа бэлэн мөнгө</b>	<b>919,896.60</b>	<b>5,655,380.57</b>
31110	Төгрөг/ЖМС	919,896.60	5,655,380.57
	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>377,546,488.07</b>	<b>57,659,489.38</b>
	<b>Төгрөг</b>	<b>50,274,517.79</b>	<b>57,482,824.38</b>
31211	Төсөвт байгууллагын харилцах	50,274,517.79	44,385,165.38
31213	Төсөвт байгууллагын харилцах /Арилжааны банк	-	13,097,659.00
	<b>Гадаад валют</b>	<b>327,271,970.28</b>	<b>176,665.00</b>
31221	Төрийн банк харилцах /Доллар/	327,271,970.28	176,665.00
31222	Төрийн банк харилцах /Юань/	-	-
	<b>Авлага</b>	<b>220,741,035.20</b>	<b>310,231,483.00</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,900,000.00	2,200,323.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	48,592,658.00	308,031,160.00
	<b>Бусад авлага</b>	<b>170,248,377.20</b>	<b>54,854,826.00</b>
3351	Байгууллагаас авах авлага	170,248,377.20	5,081,397.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	-	49,773,429.00
3353	Гэрэл цахилгааны авлага	-	-
3354	Дотоод албан томилолтын авлага	-	-
3355	Бусад зардлын тооцооны авлага	-	-
	<b>Урьдчилж гарсан зардал</b>	<b>1,349,000.00</b>	<b>190,568,503.00</b>
3471	Урьдчилгаа тооцоо	1,349,000.00	189,418,503.00
34714	Томилолтын урьдчилгаа	-	1,150,000.00
	<b>Бараа материал</b>	<b>1,668,006,460.88</b>	<b>1,720,590,246.80</b>
35410	Бичиг хэргийн материал	5,356,980.31	4,070,456.64
35420	Аж ахуйн материал	21,057,411.77	22,287,824.61
35430	Сэлбэг хэрэгсэл	1,489,631,942.69	1,524,692,566.49
35440	Түлш, шатах тослох материал	21,515,700.11	3,238,926.06
35460	Хүнсний материал	6,318.00	-
35470	Бусад бараа материал	130,438,108.00	166,300,473.00
	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	<b>-</b>	<b>-</b>
	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>2,268,562,880.75</b>	<b>2,339,559,928.75</b>
	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>-</b>	<b>-</b>
	<b>Үндсэн хөрөнгө</b>	<b>-</b>	<b>-</b>
	<b>Биет хөрөнгө</b>	<b>17,504,649,312.68</b>	<b>14,730,921,040.41</b>
	Барилга, байгууламж орон сууц	1,989,188,965.32	1,949,938,151.24
39201	Барилга байгууламж-Анхны өртөг	3,962,784,884.04	4,001,299,345.04
39202	Барилга байгууламж-Хуримтлагдсан элэгдэл	- 1,973,595,918.72	- 2,051,361,193.80
	Авто тээврийн хэрэгсэл	441,520,398.38	275,329,344.05
39203	Авто тээврийн хэрэгсэл-Анхны өртөг	999,352,799.00	999,352,799.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	- 557,832,400.62	- 724,023,454.95
	Машин тоног төхөөрөмж	14,986,188,371.07	12,407,713,081.93
39205	Машин тоног төхөөрөмж-Анхны өртөг	29,814,611,010.62	30,013,704,204.62
39206	Хуримтлагдсан элэгдэл	- 14,828,422,639.55	- 17,605,991,122.69
	Тавилга, аж ахуйн эд хогшил	83,259,897.84	94,338,963.12
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил-Анхны өртөг	224,460,179.00	257,240,107.90
39208	Хуримтлагдсан элэгдэл	- 142,284,101.16	- 162,901,144.78
	Бусад үндсэн хөрөнгө	5,575,500.07	3,601,500.07
39214	Бусад үндсэн хөрөнгө-Анхны өртөг	13,322,976.00	13,322,976.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	- 7,747,475.93	- 9,721,475.93
	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>63,339,791.84</b>	<b>36,869,791.72</b>
	Программ хангамж	63,339,791.84	36,869,791.72
39301	Программ хангамж-Анхны өртөг	113,950,480.00	113,950,480.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	- 50,610,688.16	- 77,080,688.28

01 Төрийн аудитын байгууллага  
ЗӨРЧИЛӨӨ  
САНАГДЭХЭГ

	Бусад биет бус хөрөнгө	-	-
39303	Бусад биет бус хөрөнгө-Анхны өртөг	3,770,000.00	3,770,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	- 3,770,000.00	- 3,770,000.00
	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>17,567,989,104.52</b>	<b>14,767,790,832.13</b>
	<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>19,836,551,985.27</b>	<b>17,107,350,760.88</b>
	<b>Нийт өр төлбөрийн дүн</b>		-
	<b>Өглөг</b>	<b>31,856,034.48</b>	<b>275,154,751.88</b>
4131	Ажилчидтай холбогдсон өглөг	30,832,280.48	88,976,961.88
4133	ХАОАТ-ын өглөг	-	-
4136	<b>Бусад өглөг</b>	<b>1,023,754.00</b>	<b>186,177,790.00</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	-	179,923,200.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	6,254,590.00
	<b>Урьдчилж орсон орлого</b>	<b>3,416,500.00</b>	-
41440	Бусад урьдчилж орсон орлого	3,416,500.00	-
	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	-	-
	Ур хугацаат өр төлбөрийн дүн	-	-
	<b>УРТ ХУГЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>	-	-
	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>	<b>35,272,534.48</b>	<b>275,154,751.88</b>
	<b>Цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>19,801,279,450.79</b>	<b>16,832,196,009.00</b>
51	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ Орон нутгийн сан	13,058,417,039.87	13,058,417,039.87
	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>6,742,862,410.92</b>	<b>3,773,778,969.13</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	8,514,499,797.22	5,308,952,780.47
51220	Тайлант үеийн үр дүн	- 3,205,547,016.75	- 2,969,083,441.79
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,433,909,630.45	1,433,909,630.45
	<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгийн өмчийн дүн</b>	<b>19,836,551,985.27</b>	<b>17,107,350,760.88</b>
	<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгийн өмчийн дүн</b>	<b>19,836,551,985.27</b>	<b>17,107,350,760.88</b>



<b>"Радио Телевизийн Үндэсний Сүлжээ" УТҮГ</b>			
<b>АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН</b>			
<b>2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар</b>			
			<i>(төгрөгөөр)</i>
Дансны код	□□□□□□□□	өмнөх он	Тайлант он
	<b>Үйл ажиллагааны орлогын дүн</b>	<b>3,909,886,030.09</b>	<b>4,657,104,800.58</b>
	<b>Төсвөөс санхүүжсэн</b>	<b>2,244,876,000.00</b>	<b>2,941,307,000.00</b>
	<b>Улсын төсвөөс</b>	<b>2,244,876,000.00</b>	<b>2,941,307,000.00</b>
131001	Урсгал /Гатаас санхүүжилт/	2,244,876,000.00	2,931,102,000.00
131002	Хөрөнгийн		10,205,000.00
120002	<b>Хүүгийн орлого</b>	<b>29,257,149.27</b>	<b>6,510,949.15</b>
	<b>Төсөвт байгуулагын орлого</b>	<b>1,635,752,880.82</b>	<b>1,709,286,851.43</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого	1,198,617,110.42	1,276,919,980.45
1200042	Туслах үйл ажиллагааны орлого		372,866,435.98
120009+	Бусад орлого	426,759,740.00	59,500,435.00
	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	71,000.00	
	Хандив тусламж-гадаад	10,305,030.40	
	<b>Үйл ажиллагааны орлогын дүн (I)</b>	<b>3,909,886,030.09</b>	<b>4,657,104,800.58</b>
	<b>Урсгал зардал</b>		-
	<b>Бараа, ажил үйлчилгээний зардал</b>	<b>2,340,813,646.04</b>	<b>2,521,810,903.38</b>
	<b>Цалин хөлс нэмэгдэл урамшил</b>	<b>2,109,005,554.66</b>	<b>2,271,643,194.12</b>
210101+*	Цалин	2,109,005,554.66	2,271,643,194.12
	Бусад нэмэгдэл цалин		
	<b>Ажил олгогоос төлөх НДШ</b>	<b>231,808,091.38</b>	<b>250,167,709.26</b>
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	193,134,266.73	206,332,136.38
210205	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	38,673,824.65	43,835,572.88
	<b>Бараа ажил үйлчилгээний зардал</b>	<b>4,970,634,113.95</b>	<b>5,097,408,909.51</b>
	<b>Тогтмол зардал</b>	<b>925,132,050.86</b>	<b>1,145,895,160.85</b>
210301	Гэрэл цахилгааны зардал	850,918,063.46	1,062,677,319.85
210302	Түлш халаалтын зардал	61,544,478.40	70,050,669.50
210303	Цэвэр бохир усны зардал	10,885,909.00	11,400,771.50
210304	Байрны түрээс	1,783,600.00	1,766,400.00
	<b>Хангамж бусад бараа материалын зардал</b>	<b>151,357,927.77</b>	<b>155,930,825.02</b>
210401+*	Бичиг хэргийн материал	10,504,268.00	14,914,105.69
210402+*	Тээвэр шатахууны зардал	90,124,421.91	71,747,139.97
210403	Шуудан холбооны зардал	34,524,269.87	29,231,723.22
210404	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс	15,703,378.11	28,729,085.60
210407	Аж ахуйн материалын зардал		9,927,090.54
210404	Ном, хэвлэлийн зардал	366,589.88	568,180.00
210405	Хог хаягдал устгах цэвэрлэх	135,000.00	813,500.00
	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>107,603,529.04</b>	<b>106,507,293.18</b>
210701	Гадаад томилолтын зардал	64,089,469.04	48,981,758.18
210702	Дотоод албан томилолтын зардал	43,514,060.00	57,525,535.00
	<b>Нормативт зардал</b>	<b>8,667,251.50</b>	<b>8,296,444.00</b>
210503	Нормын хувцас зөөлөн эдлэл	8,667,251.50	8,296,444.00
	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр</b>	<b>376,929,201.29</b>	<b>353,840,006.47</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	149,220,562.44	141,619,839.12
210802	Аудит баталгаажуулалт	9,000,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээний төлбөр	7,910,930.00	49,945,816.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,855,900.00	2,279,300.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээний хөлс	152,186,497.00	90,419,551.75
210807	Газрын төлбөр	44,273,305.00	68,590,363.00
210808	Банкны үйлчилгээний хураамж	1,262,023.11	985,136.60
	Олон улсын гишүүнчлэлийн татвар	11,219,983.74	
	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>184,829,531.19</b>	<b>190,042,163.40</b>
210604	Урсгал засварын зардал	184,829,531.19	190,042,163.40
	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>3,118,415,200.28</b>	<b>3,080,779,843.59</b>
210901	Бусад зардал	52,000.00	2,928,987.00
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	970,000.00	7,265,000.00
210903	Хуримтлагдсан элэгдэл	3,117,393,200.28	3,070,585,839.59
210907	Сургалт семинарын зардал		
210910	Олон улсын гишүүнчлэлийн татвар		



	<b>Урсгал шилжүүлэг</b>	<b>97,699,422.02</b>	<b>56,117,173.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж	96,799,422.02	55,120,373.00
213210	Шагнал тэтгэмж	900,000.00	996,800.00
	<b>Үйл ажиллагааны зардлын дүн (I)</b>	<b>7,311,447,759.99</b>	<b>7,619,219,812.89</b>
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>(3,401,561,729.90)</b>	<b>(2,962,115,012.31)</b>
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО</b>		-
145001	Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз(бодит)	233,484,136.85	-
145002	Үндсэн хөрөнгө худалдсаны олз	22,000,000.00	-
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)</b>	<b>255,484,136.85</b>	-
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ</b>		-
225001	Гадаад валютын ханшийн зөрүүгийн гарз (бодит)	52,303,866.46	6,968,429.48
	Үнэ төлбөргүй гарсан зардал		
225002	Хөрөнгө худалдсаны гарз	7,165,557.24	-
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>59,469,423.70</b>	<b>6,968,429.48</b>
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГЫН НИЙТ ҮР ДҮН</b>	<b>(3,205,547,016.75)</b>	<b>(2,969,083,441.79)</b>






**"Радио Телевизийн Үндэсний Сүлжээ" УТҮГ**

**АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

**2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар**

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	<b>2015 оны 01-р сарын 01-ээрх орлого</b>	<b>13,058,417,039.87</b>	<b>1,478,083,909.45</b>	<b>3,447,243,843.93</b>	<b>17,983,744,793.25</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		(1,596,803.50)	1,596,803.50	
3	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>13,058,417,039.87</b>	<b>1,476,487,105.95</b>	<b>3,448,840,647.43</b>	<b>17,983,744,793.25</b>
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт		5,373,100.00		5,373,100.00
5	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
7	Тайлант үеийн үр дүн			5,035,170,030.97	5,035,170,030.97
8	2015 оны аудитын залруулга				
9	<b>2016 оны 01-р сарын 01-ээрх орлого</b>	<b>13,058,417,039.87</b>	<b>1,481,860,205.95</b>	<b>8,484,010,678.40</b>	<b>23,024,287,924.22</b>
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			(17,461,456.68)	(17,461,456.68)
11	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>13,058,417,039.87</b>	<b>1,481,860,205.95</b>	<b>8,466,549,221.72</b>	<b>23,006,826,467.54</b>
12	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт		(47,950,575.50)	47,950,575.50	-
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				-
14	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
15	Тайлант үеийн үр дүн			(3,205,547,016.75)	(3,205,547,016.75)
16	2015 оны аудитын залруулга				
17	<b>2016 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>13,058,417,039.87</b>	<b>1,433,909,630.45</b>	<b>5,308,952,780.47</b>	<b>19,801,279,450.79</b>
18	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
19	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>13,058,417,039.87</b>	<b>1,433,909,630.45</b>	<b>5,308,952,780.47</b>	<b>19,801,279,450.79</b>
20	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				
21	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				
22	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
23	Тайлант үеийн үр дүн			(2,969,083,441.79)	(2,969,083,441.79)
24	<b>2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>13,058,417,039.87</b>	<b>1,433,909,630.45</b>	<b>2,339,869,338.68</b>	<b>16,832,196,009.00</b>




**"Радио Телевизийн Үндэсний Сүлжээ" УТҮГ  
АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар

(төгрөгөөр)


Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>3,893,757,429.07</b>	<b>4,249,824,296.38</b>
	<b>Төсөвт байгууллагын өөрийн орлого</b>	<b>1,648,881,429.07</b>	<b>1,318,529,137.38</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,187,460,965.42	867,279,225.13
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	432,401,664.20	386,221,901.81
120009	Бусад орлого	29,018,799.45	65,028,010.44
	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,244,876,000.00</b>	<b>2,931,295,159.00</b>
	Улсын төвлөрсөн төсвөөс	2,244,876,000.00	2,931,102,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,244,876,000.00	2,931,102,000.00
	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	193,159.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	193,159.00
	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)</b>	<b>4,931,897,536.22</b>	<b>4,354,325,713.61</b>
	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>4,931,897,536.22</b>	<b>4,354,325,713.61</b>
	<b>БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>4,692,429,486.42</b>	<b>4,299,887,340.61</b>
	<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>2,097,723,897.98</b>	<b>2,221,926,642.21</b>
210101	Үндсэн цалин	2,097,723,897.98	2,221,926,642.21
	<b>Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>216,200,808.32</b>	<b>241,833,211.17</b>
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	140,069,849.89	154,875,091.76
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	15,286,000.73	17,839,213.79
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	18,961,585.45	21,087,149.35
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	3,880,887.61	5,067,257.23
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	38,002,484.64	42,964,499.04
	<b>Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал</b>	<b>921,394,888.84</b>	<b>1,031,929,766.85</b>
210301	Гэрэл цахилгааны зардал	851,484,579.84	966,683,045.85
210302	Түлш, халаалтын зардал	57,336,800.00	52,156,549.50
210303	Цэвэр, бохир усны зардал	10,789,909.00	11,323,771.50
210304	Байрны түрээс	1,783,600.00	1,766,400.00
	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>153,209,168.75</b>	<b>191,093,460.25</b>
210401	Бичиг хэрэг	10,494,716.00	16,349,280.00
210402	Тээвэр, шатахуун	94,437,300.00	71,900,417.03
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	34,448,159.87	28,313,028.22
210404+*	Ном, хэвлэл	1,172,989.88	568,180.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	135,000.00	810,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,521,003.00	62,028,207.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	11,124,348.00
	<b>Нормативт зардал</b>	<b>17,830,269.00</b>	<b>10,242,020.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	17,830,269.00	10,242,020.00
	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>847,458,795.20</b>	<b>203,899,401.00</b>
210601	Багаж техник хэрэгсэл	-	19,004,350.00
210602	Тавилга	-	640,000.00
210604	Урсгал засвар	847,458,795.20	184,255,051.00
	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>105,114,439.04</b>	<b>106,923,783.18</b>
210701	Гадаад албан томилолт	64,089,469.04	44,775,000.20
210702	Дотоод албан томилолт	41,024,970.00	62,148,782.98
	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>332,487,219.29</b>	<b>283,378,655.95</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	118,475,544.54	124,291,394.01
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	9,000,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	7,910,930.00	49,945,812.99
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,855,900.00	2,279,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	268,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	138,489,532.99	19,345,335.35
210807	Газрын төлбөр	44,273,805.00	26,263,672.00



210808	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,262,023.11	985,136.60
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	11,219,983.74	-
	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,010,000.00</b>	<b>8,660,400.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	40,000.00	1,395,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх	970,000.00	7,265,000.00
	<b>ТАТААС</b>		-
	Төрийн өмчит байгууллагад олгох татаас		-
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас		-
	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>239,468,049.80</b>	<b>54,438,373.00</b>
213201	Бусад урсгал шилжүүлэг	900,000.00	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	141,791,850.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	96,776,199.80	54,438,373.00
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>(1,038,140,107.15)</b>	<b>(104,501,417.23)</b>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>264,286,684.00</b>	203,681,668.00
	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	264,286,684.00	203,681,668.00
	Дотоод эх үүсвэрээр	264,286,684.00	203,681,668.00
220001	Барилга байгууламж		65,900,000.00
222001	Тоног төхөөрөмж		124,657,468.00
223001	Бусад хөрөнгө		13,124,200.00
	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал /ТӨҮГ/	264,286,684.00	-
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(264,286,684.00)</b>	<b>(203,681,668.00)</b>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	-	-
145001	Гадаад валютын ханшийн зөрүү	181,180,270.40	6,968,429.49
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	181,180,270.40	6,968,429.49
	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>(1,121,246,520.75)</b>	<b>(301,214,655.74)</b>
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,499,712,905.42	378,466,384.67
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	378,466,384.67	63,314,869.95



<b>"Радио Телевизийн Үндэсний Сүлжээ" УТУГ</b>					
<b>АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН</b>					
2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар				/төгрөгөөр/	
Дансны код	ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	Тайлант он	Зөрүү	Хувь
	<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>	<b>7,921,458,100.00</b>	<b>4,558,007,381.62</b>	<b>3,363,450,718.38</b>	<b>57.5</b>
	II. НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	7,921,458,100.00	4,558,007,381.62	3,363,450,718.38	57.5
	III. УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	7,921,458,100.00	4,354,325,713.62	3,567,132,386.38	55.0
	<b>Бараа ажил үйлчилгээний зардал</b>	<b>7,799,894,500.00</b>	<b>4,299,887,340.62</b>	<b>3,500,007,159.38</b>	<b>55.1</b>
	<b>Цалин хөлс, нэмэгдэл урамшил</b>	<b>2,416,913,400.00</b>	<b>2,221,926,642.21</b>	194,986,757.79	91.9
210101	Үндсэн цалин	2,416,913,400.00	2,221,926,642.21	194,986,757.79	91.9
	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>266,177,400.00</b>	<b>241,833,211.17</b>	<b>24,344,188.83</b>	<b>90.9</b>
210201	Тэтгэвэрийн даатгал	170,465,624.01	154,875,091.76	15,590,532.25	90.9
210202	Тэтгэмжийн даатгал	19,635,001.83	17,839,213.79	1,795,788.04	90.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	23,209,891.48	21,087,149.35	2,122,742.13	90.9
210204	Ажилгүйдлийн даатгал	5,577,353.70	5,067,257.23	510,096.47	90.9
210205	Эрүүл мэндийн даатгал	47,289,528.98	42,964,499.04	4,325,029.94	90.9
	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>1,733,977,700.00</b>	<b>1,031,929,766.85</b>	<b>702,047,933.15</b>	<b>59.5</b>
210301	Гэрэл цахилгааны зардал	1,660,961,400.00	966,683,045.85	694,278,354.15	58.2
210302	Түлш халаатын зардал	60,191,200.00	52,156,549.50	8,034,650.50	86.7
210303	Цэвэр бохир усны зардал	12,825,100.00	11,323,771.50	1,501,328.50	88.3
210304	Байр түрээс	2,126,400.00	1,766,400.00	360,000.00	83.1
	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>337,603,500.00</b>	<b>191,093,460.25</b>	<b>146,510,039.75</b>	<b>56.6</b>
210401	Бичиг хэргийн материал	21,908,600.00	16,349,280.00	5,559,320.00	74.6
210402	Тээвэр шатахууны зардал	107,587,600.00	71,900,417.03	35,687,182.97	66.8
210402	Шуудан холбооны зардал	33,832,800.00	28,313,028.22	5,519,771.78	83.7
210404+*	Ном хэвлэл	2,652,800.00	568,180.00	2,084,620.00	21.4
	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	720,000.00	810,000.00	(90,000.00)	112.5
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	170,901,700.00	73,152,555.00	97,749,145.00	42.8
	<b>Норматив зардал</b>	<b>28,155,300.00</b>	<b>10,242,020.00</b>	17,913,280.00	36.4
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	28,155,300.00	10,242,020.00	17,913,280.00	36.4
	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,164,540,000.00</b>	<b>203,899,401.00</b>	<b>960,640,599.00</b>	<b>17.5</b>
210604	Урсгал засвар	1,164,540,000.00	203,899,401.00	960,640,599.00	17.5
	<b>Томилолт зочны зардал</b>	<b>274,110,000.00</b>	<b>106,923,783.18</b>	<b>167,186,216.82</b>	<b>39.0</b>
210701	Гадаад албан томилолт	115,482,900.00	44,775,000.20	70,707,899.80	38.8
210702	Дотоод албан томилолт	158,627,100.00	62,148,782.98	96,478,317.02	39.2
	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>920,960,200.00</b>	<b>292,039,055.96</b>	<b>628,921,144.04</b>	<b>31.7</b>
	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	526,398,800.00	124,291,394.00	402,107,406.00	23.6
210802	Аудит баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	9,000,000.00	-	9,000,000.00	0.0
210803	Даатгалын үйлчилгээ	59,509,100.00	49,945,816.00	9,563,284.00	83.9
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,875,900.00	2,279,300.00	(403,400.00)	121.5
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	262,550,000.00	79,345,335.35	183,204,664.65	30.2
210807	Газрын төлбөр	55,126,400.00	26,263,677.00	28,862,723.00	47.6
210808	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		985,136.60	(985,136.60)	
210810	Олон улсын татвар	6,500,000.00	-	6,500,000.00	0.0
	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>24,630,000.00</b>	7,931,597.01	16,698,402.99	32.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,663,397.01	(1,663,397.01)	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	24,630,000.00	7,265,000.00	17,365,000.00	29.5
	<b>ТАТААС</b>	<b>121,563,600.00</b>	<b>54,438,373.00</b>	<b>67,125,227.00</b>	<b>44.8</b>
212101	Татаас санхүүжилт орон нутаг /мөнгөөр/		-	-	
	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>121,563,600.00</b>	<b>54,438,373.00</b>	<b>67,125,227.00</b>	<b>44.8</b>
2103203	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	60,000,000.00	-	60,000,000.00	0.0
213205	Төрөөс иргэдэд үзүүлэх бусад тэтгэмж, урамшуулал		-	-	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал, урамшуулал	61,563,600.00	54,438,373.00	7,125,227.00	88.4
	<b>Хөрөнгийн зардал</b>	<b>632,827,000.00</b>	<b>203,681,668.00</b>	<b>429,145,332.00</b>	<b>32.2</b>
220001	Барилга байгууламж	4,200,000.00	65,900,000.00	(61,700,000.00)	1569.0
222001	Тоног төхөөрөмж	628,627,000.00	124,657,468.00	503,969,532.00	19.8
223001	Бусад хөрөнгө		13,124,200.00	(13,124,200.00)	
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>7,923,584,500.00</b>	<b>4,249,824,296.38</b>	<b>3,673,760,203.62</b>	<b>53.6</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,931,102,000.00	2,931,102,000.00	-	100.0
	Улсын төсвөөс санхүүжих		193,159.00	(193,159.00)	



	<b>Төсөөт байгууллагын үйл ажиллагаанаас</b>	<b>1,849,350,800.00</b>	<b>1,318,529,137.38</b>	<b>530,821,662.62</b>	<b>71.3</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,426,577,400.00	867,279,225.13	559,298,174.87	<b>60.8</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	422,773,400.00	451,249,912.25		<b>106.7</b>
	<b>Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>378,466,384.67</b>	(378,466,384.67)	
	<b>Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>63,314,869.95</b>	(63,314,869.95)	
	<b>Өмнөх оны дутуу санхүүжилт</b>	<b>3,143,131,700.00</b>			
	<b>Байгууллагын тоо</b>		-		
	Ажиллагсад бүгд		217		
	Удирдах ажилтан		24		
	Гүйцэтгэх ажилтан		137		
	Үйлчлэх ажилтан		49		
	Гэрээт ажилтан		7		

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**



**01**

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**